

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ТЭРГҮҮНД НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хорооны үйл ажиллагааг гишүүд хуульчдын оролцоог бүрэн хангасан, үр дүнтэй зохион байгуулж, хорооны үйл ажиллагааны зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлэх үүднээс Хорооны тэргүүнд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн нэг жилийн хугацаанд Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хорооноос зохион байгуулсан 2 ба түүнээс дээш үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцсон байх;
2. Хуульчийн Про боно үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг байх;
3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу МХХ-ны гишүүний үүргийн зөрчилгүй байх;

Хорооны тэргүүнд нэр дэвшигч нь дээрх шаардлагуудын аль нэгийг хангаагүй тохиолдолд Тооллогын комиссоос нэр дэвшигчид өөрт нь мэдэгдэж, нэр дэвшигчдийн жагсаалтаас хасна.

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хорооны гишүүнчлэлтэй, сүүлийн нэг жилийн хугацаанд хорооноос зохион байгуулсан аль нэг ажилд оролцсон байх;
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу үүргийн МХХ-ны гишүүний үүргийн зөрчилгүй байх. (Сүүлийн 2 жилээс дээш хугацааны татварын өр болон сургалтын багц цагийн үлдэгдэлгүй байх).

Хорооны удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дээрх шаардлагуудын аль нэгийг хангаагүй тохиолдолд Тооллогын комиссоос нэр дэвшигчид өөрт нь мэдэгдэж, нэр дэвшигчдийн жагсаалтаас хасна.